



ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2013 оны 08 дугаар сарын 14-ний өдөр
Тендер шалгаруулалтын нэр: Монголбанкинд автомашин нийлүүлэх
Тендер шалгаруулалтын дугаар: CR-2013/02

Монголбанк нь эрх бүхий тендерт оролцогчоос ажлын хэрэгцээнд зориулан автомашин нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна. Тендер нь дараах багцтай байна. Үүнд:

Багц 1.Суудлын автомашин,
Багц 2.Дунд оврын автомашин /van/.

Тендерийн бичиг баримтыг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000.00 (тавин мянган) төгрөгөөр худалдан авч болно. Тендерийн баримт бичгийн үнийг Монголбанкны 4101000014 тоот дансанд тушаана. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
Борлуулалтын хэмжээ: 300,000,000.00 (гурван зуун сая) төгрөг,
Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: 300,000,000.00 (гурван зуун сая) төгрөг,
Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх он: 2012, 2011 он.

Тендерийн хамт тендерт оролцохоор санал болгож байгаа үнийн дүнгийн 2 (хоёр) хувьтай тэнцэх хэмжээний төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ. Гадаадын этгээд тендерт оролцох эрхгүй бөгөөд тендерт оролцогчид давуу эрхийн зөрүү тооцохгүй болно. Хувилбарт тендер ирүүлэхийг зөвшөөрөхгүй.

Тендерийг 2013 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 10 цаг 00 минутаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2013 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 10 цаг 30 минутанд нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн бичиг баримт болон бусад мэдээллийн доорх хаягаар авч болно.

**Монголбанк,
Бага тойруу -3, 15160, Улаанбаатар хот,
Монголбанкны “А” байрны 1 давхар, 2 тоот өрөө**

Утас: (976) 11-310633, 327048, Факс: (976) 11-311471